

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ЛАБОРАТОРИ 23 ДУГААР СУРГУУЛИЙН БАГА
БОЛОВСРОЛЫН БАГШ М.АРИУНЦЭЦЭГИЙН
ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

2018-2019 он

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ
23 ДУГААР СУРГУУЛИЙН БАГА БОЛОВСРОЛЫН
БАГШ М.АРИУНЦЭЦЭГИЙН 2018-2019 ОНЫ
ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

I. Төлөвшил

➤ **Оролцоо**

- 2018-2019 оны хичээлийн жилд “Бусдад туслаж, бусдаасаа суралцаа” уриаг зорилт тавин ангийн сурагчдаа идэвхитэй оролцуулж сургуулийн дэг, ангийн дэгийг баримтлан мөрдөхөд сурагч нэг бүрдээ шаардлага тавин ажилласан.
- Хичээлээс гадуурх ажлын хүрээнд:
 - I улиралд навчин наамал зохиомжит
 - II улиралд “Багшдаа хайртай” зургийн үзэсгэлэнг бүтээлийн самбарт гаргаж шилдэг бүтээлийн эзнээр тэргүүн байр Б. Оргил, дэд байр С. Төртүвшин III байр Ч. Цэлмүүн нар шалгарлаа.
- МУБИС-н багш Ц. Нямжавын нэрэмжит 1-р шатны математикийн олимпиадад ангиараа оролцож 71,2 % гүйцэтгэлтэйгээр амжилт үзүүлж, 21 сурагч шилдэг үзүүлэлтийг хангасан. Үүнд: А.Анужин, Э.Анхчимэг, М.Батзолбоо, М.Баттүшиг, Ш.Бүжин, С.Лаура, Ганб. Маргад, Ж.Мишээл, Б.Мишээл, Б.Мөнхгэрэл, Д.Нарангуа, Н.Намуундарь, Ч.Номин- Эрдэнэ, О. Оджаргал, С.Оюу-Эрдэнэ, Г.Төгөлдөр- Яруу, А.Хүслэн, Я.Цэлмүүн, М.Энгүүн, Ч.Энгүүн, Г.Эрдэмтөгс, мөн сэтгэх чадварын намрын сорилгод Н.Намуундарь топ үнэлгээ үзүүлж, 2-р шатанд амжилттай оролцож Н.Намуундарь, А.Анужин, Б.Мишээл сурагчид хүрэл медалийн эзэд болсон.
- Хаврын улиралд ногоо, мах, хүнсний шим тэжээл багасч өдөр уртасдаг тул хүүхдүүд амин дэмээр дутагддагтай холбоотойгоор нийт сурагчдыг витаминжуулах аян зохион байгуулсан.
- Эцэг эхийн дунд Шилжин явах цомтой Сагсан бөмбөг болон Гар бөмбөгийн спортын тэмцээн амжилттай зохион байгуулсан.
- Сурагчдын дунд Монгол ёс заншил, танин мэдэхүйн сэдвээр асуулт, хариултын тэмцээн явуулж, сурагчдын сэтгэн бодох болон оюуны чадварыг дээшлүүлэх, уран сэтгэмжийг хөгжүүлэх, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор АХА тэмцээн 2019 оны 05-р сарын 15-ны өдөр сургууль дээрээ амжилттай зохион байгуулж тэргүүн байр Д.Нарангуа, дэд байр Б.Ихбаяр, III байр Ш.Гарьд-Очир нар шалгарлаа.

Б. Дадал хэвшил

- Сурагч нэг бүр дүрэмт хувцас, биеийн тамирын хувцасаа зөв , цэвэр өмсөж хуваарын дагуу хичээлийн бэлтгэлийг хангаж ирсэн.
- Хичээлийн оролт, гаралт завсарлагааны үеийн дэгийг баримталдаг.
- Сурагч бүр цацруулагчаа ашиглаж хэвшсэн.
- Сурагчдыг хичээлд орох, тарах үед эцэг эхийн 6 баг 7 хоногоор ээлжлэн зохицуулалт хийж эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж сайн ажиллагаа болгон хэвшүүлэн, сургуулийн хэмжээнд үлгэр жишээ болон ажиллаж байна.

В. Зан чанар

- Ангийн нийт сурагчид бие биенээ хүндлэх уучлалт гуйх, талархлын ба уучлалын захидал бичих ажлуудыг зохион явуулсан.

II.Мэдлэг чадварын ахиц

Хичээл заалт

№	Хичээлийн нэр	Заах ёстой цаг	Заасан цаг	Нийт цаг
1	Математик	5	165	165
2	Монгол хэл	7	231	231
3	Хүн орчин	3	99	99
4	Дүрслэх урлаг	2	66	66
5	Иргэний боловсрол	1	33	33
6	ХГҮА	1	33	33
Нийт	6	19	627	627

- 2018-2019 оны хичээлийн жилд нийт 6 хичээлийг 627 цаг зааж, хөтөлбөрүүдийг Мүүдл системд оруулж, бага боловсролыг хариуцсан менежер З.Тунгалагаар хөтөлбөрөө батлуулж, сургалтын үйл ажиллагаагаа явуулсан.
- Багшийн ажлын дэвтэрийг сар бүр, багшийн журналыг тогтмол хөтөлж, хариуцсан менежерээр хянуулж, баталгаажуулсан.

Г. Боловсролын үйлчилгээний сэтгэл ханамж

- Сургуулийн Муудл шат дараалсан сургалтанд хамрагдсан.

- МУБИС дээр олон улсын хүн ба байгаль, хүн нийгэм, хичээлүүдийг заах сургагч багшийн сургалтанд хамрагдсан.
- МУБИС-н 3 оюутанг дадлагажуулсан.

Д. Сурагч бүрийн эрүүл мэндийг хамгаалахад оруулсан хувь нэмэр

- Сургуулийн эмчтэй хамтарч бүх сурагчдыг өндөр жингийн үзлэгт хамруулсан.
- Эрүүл мэндийн боловсрол сургалтыг Чингэлтэй дүүргийн ЭМТ-н ёс зүйн хорооны дарга хүүхдийн их эмч М. Цэвээн зохион байгууллаа.
- Сургуулийн эмчтэй хамтарч бүх сурагчдыг өндөр жингийн судалгаа болон томуугийн вакцинжуулалтанд хамруулсан.
- Гэмт ослоос урьдчилан сэргийлж хүүхэд бүрийн цүнхэнд цацруулагч хадуулсан.
- Үдийн цайны дэгийг баримтлан гарын ариун цэврийг сахиулах нойтон болон хуурай салфетка, санитол хэрэглэж хэвшсэн. Үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг хавсаргав.

ТАЙЛАН БИЧСЭН: БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ

М.АРИУНЦЭЦЭГ

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23-Р СУРГУУЛИЙН 2В
АНГИЙН НЭРЭМЖИТ ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ГАР БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНИЙ АЛТАН
МЕДАЛЬ АВСАН 2Б АНГИЙН ТАМИРЧИД**

